

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН УСНЫ ХЭМНЭЛТ, ИННОВАЦИ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ДОРЖПАГМАЖАВ ОВОГТОЙ УРАНТЭСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДАХИН АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, УС БОХРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Усны нөөцийг тогтоох, усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, бохирдол, хомсдлоос сэргийлэх "Алсын хараа 2050" хөтөлбөрийн зорилт 5.1.2, 6.3, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 6.3.1, ЗГ-ын 2024-2028 оны УАХ-ийн 2.4.3.6, 2.4.3.7, 3.4.1.7, 3.4.2.5, 3.4.3.4, 4.3.1.4, БОУАӨЯ-ны стратегийн зорилт 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5; Усны газрын стратеги төлөвлөгөөний 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6.2.7							
1.	Арга хэмжээ 1.1 Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.	Усны чанарын үнэлгээ хийсэн сумын тоо	-	Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн 44 сумын усны чанарт үнэлгээ хийх ажлын хуваарь гаргаж, бэлтгэл ажлыг хангасан байна.	1. Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Сайн шанд сумын малчдын унд ахуйн гүний худгуудаас 2 удаагийн давтамжтай, 8 цэгээс дээж авч хими, нянгийн шинжилгээг хийж усны газрын даргад гарсан үр дүнг танилцуулж, "БАДРАХ ЭНЕРЖИ"ХХК-д дүгнэлт зөвлөмж хүргүүлж, цаашид давтамжийг сар бүр тогтмол авч цооног болон ойр орчмын гүний худгуудаас мониторинг хийх ажлын төлөвлөгөө гаргаж, ажлын хэсгийн ахлагч Ус ашиглалтын хэлтсийн дарга /Х.Мягмаржав/-д өгч ажилласан.	01 06	100%
2.	Арга хэмжээ 1.2. Усны хяналтын төв лабораторийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах.	"Лаборатор"-ийн ажлын гүйцэтгэлийн хувь	100%	Лабораторийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай урвалж бодис, хүний нөөцийн асуудлыг зохион байгуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.	1. Лаборатори нь хийсэн шинжилгээний нийт тоо хэмжээ буюу төсөвт төвлөрүүлэх төлбөрт, хувиар тооцвол 84.64%-н биелэлттэй. Нийт шинжилгээний тоогоор 108.1%-н гүйцэтгэлтэй ажилласан. 2. Лабораторийн ажилчидад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 3. Цэвэр усны химийн шинжилгээний лабораторид стандарт ширээ, дээж хадгалах хөргөгч, Бохир усны шинжилгээний лабораторид сорох шүүгээ, дээж хадгалах хөргөгч, химийн бодис хадгалах өрөөнд химийн бодис хадгалах стандарт кабинет, аргон хий хадгалах стандарт кабинет, стандарт	01 06	100%

					бодис хадгалах хөргөгч, хүнд металлын лабораторид ус ионгүйжүүлэгч аппарат, микробиологийн лабораторид цэвэр усны дээж хадгалах хөргөгч зэргийг шинээр авч тохижилтын ажлыг зохион байгуулж ажилласан. 4. МСС-н компакт гэрээний хүрээнд ирсэн 2 хаалгатай хөргөгч-, 1 хаалгатай хөргөгч, нүд угаагч-3ш, температур хэмжигч-4ш, органик бодис тодорхойлогч-1ш, шил сав угаагч автомат, сорох шүүгээ, плитка, нацос, шүүлтүүр 3-тай, шүүлтүүр 6-тай, BOD ингибатор, хатаах шүүгээ, дээж бэлтгэгч, сульфид тодорхойлох багаж, хүнд металл тодорхойлох ICPE-AOS багаж ком суурилуулах ажлыг зохион байгуулж шинээр бохир усны химийн лабораторийг байгуулж ажилласан.		
3	Арга хэмжээ 1.3. Усны хяналтын төв лабораторид ирсэн усны дээжүүдэд цэвэр, бохир усны хими, микробиологи, хүнд металлын шинжилгээ хийж, үр дүнг боловсруулж иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлэх.	Шинжилгээний тоо	2024 онд нийт 2757 шинжилгээ хийгдсэн	Цэвэр усны хими 410, бохир усны хими 205, хүнд металл 200, цэвэр усны нян судлал 370, бохир усны нян судлалын 120 сорьцод шинжилгээ хийсэн үр дүнг хянаана.	Цэвэр усны хими-420, бохир усны хими-185, хүнд металл-160, цэвэр усны нян судлал-550, бохир усны нян судлал-96 сорьцонд хийсэн шинжилгээний үр дүнг хянасан.	01 06	95%
4	Арга хэмжээ 1.4. Усны хяналтын төв лабораторийг давтан итгэмжлэлд хамруулах.	Итгэмжлэл-ийн батламж	2019 онд итгэмжлэгдсэн.	Лабораторийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан байна. Химийн бодис ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл авсан байна. Байгаль орчны төлөв байдлын тайлан хийлгэсэн байна. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт, шинжилгээтэй хяналт хийлгэсэн байна. Итгэмжлэлд хамрагдахад шаардлагатай бичиг баримтын	ҮИТ-д лабораторийн үйл ажиллагааг итгэмжлэлд хамруулах шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, 50 баримт бичгийг бэлтгэн материалыг хүргүүлж ажилласан. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, лабораторийн ажлын байранд дүгнэлт гаргуулж ажилласан. Химийн бодис ашиглах зөвшөөрөл гаргуулах ажлыг зохион байшуулж БОУАӨЯамруу албан бичиг хүргүүлж ажилласан.	01 06	100%


				бүрдэл, бэлтгэл ажлуудыг хангасан байна.			
5	Арга хэмжээ 1.5. Савласан усны стандартын хэрэгжилтэд хяналт тавих	Хяналт тавин ажилласан тоо	1	Савласан усны стандартын хэрэгжилтэд 1 удаа хяналт тавин ажилласан байна.	Нийт 10 нэр төрлийн савласан усанд хими болон нянгийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан. /1-удаа/. Үр дүнг усны газрын даргад 2025.02.27-нд танилцуулсан.	01 06	100%
ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ Усны тухай хуулийн 16 ¹ дугаар зүйлийн 16 ¹ .4.8, 24 дүгээр зүйлийн 24.2, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль							
1.	Арга хэмжээ 2.1. Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр олон улсын хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцох.	Оролцсон арга хэмжээний тоо	8	Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр зохион байгуулсан олон улсын арга хэмжээнд 3-аас доошгүй удаа оролцож, туршлага судлах.	"УСУГ"-ын лабораторитой цэвэр усны ерөнхий хими, нян судлал, бохир усны химийн шинжилгээгээр зэрэгцээ шинжилгээг хийж үр дүнг баталгаажуулж, дүгнэлт өгч ажилласан. ХАБУЛЛ болон ГСШТөвийн зохион байгуулж байгаа УЧС-н 1-р ээлжийн тойрогт оролцох дээжийг хүлээн авч сорилтод оролцох ажлыг зохион байгуулж ажиллаж байна. УЧС-н шинжилгээний үр дүнг 2025.06.12-нд илгээнэ. Усны нөөц зохистой хамгаалах ажлын хүрээнд лабораторийн зүгээс Туул гол дагуух 6 гүүр орчимоос 2 удаагийн давталттайгаар дээж авч хими болон нянгийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, гарсан үр дүнг усны газрын даргад танилцуулсан. УБ хотын СХД-т байршилтай Гүнжийн нуурнаас авсан дээжинд хими, нян судлалын шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж гарсан үр дүнг Усны газрын даргад 2025.06.03-нд танилцуулсан.	01 06	100%
ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ /Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль/							
2.	Арга хэмжээ 3.1. Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.	"Цэнхэр алт" үндэсний чуулган зохион байгуулах. Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил зохион байгуулах"	2024 онд "Цэнхэр тууз" аяныг зохион байгуулсан	Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах.	"Цэнхэр тууз" аяны хүрээнд хийгдэх ажлын хэсэгт мандат бичих, аянд оролцохоор ирсэн хүмүүсийг бүртгэж мандат тараах ажилд идэвхитэй оролцсон.	01 06	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. А3 сургалтад хамрагдах;	Сертификат авсан байна.	1	А3 сургалтад хамрагдаж, сертификат авах.	А3 сургалтад хамрагдаж, сертификат мэргэжилтэн авсан-1	01 06	100%
2.	Арга хэмжээ 2.2. Ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах;	Сургалтанд хамрагдаж сертификат авсан байна.	1	Сургалтад хамрагдах	ISO 9001 сургалтад хамрагдаж байгаа.	01 06	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УСНЫ ХЭМНЭЛТ, ИННОВАЦИ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д. УРАНТЭС /  /

2025 оны 06-р сарын 03

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА:

У.БАТЗАЯА /  /

2025 оны 06-р сарын 03

70